



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/1007

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн гаднын сургалтын байгууллагуудад 2021 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын эрэлч нохой эзэмшигчдийн холбооны Сургалтын төвд 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулагдах Нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын албаны нохой хөтлөгчийн сургалтад Аюулгүй байдал, хамгаалалтын албаны нохой хөтлөгч шалгагч Б.Жаргал, А.Баттогтох, Б.Баярбямба, үзлэгийн шалгагч Ро.Мөнхбат нарыг хамруулсугай.
2. Сургалтын зардалд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т зөвшөөрсүгэй.
3. Сургалтад хамрагдах ажилтнуудын суралцах хугацаанд ажил үүрэгт нь зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Аюулгүй байдал, хамгаалалтын алба (М.Гомбожав)-нд, сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж, тайлан гарган Нисэхийн сургалтын төвд хүлээлгэн өгөхийг Б.Жаргал, А.Баттогтох, Б.Баярбямба, Ро.Мөнхбат нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0920